



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 10 сарын 19 өдөр

Дугаар A/508

Арвайхээр

**Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн  
бэлэн байдлын үед зарим арга хэмжээ  
авах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "б", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Улсын онцгой комиссын 2021 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 27 дугаар хурлын тэмдэглэлийн 6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Спорт заал, усан бассейн, фитнесс, баар, караоке, зоогийн газар, рестораны үйл ажиллагааг 2021 оны 11 дүгээр сарын 31-ний өдөр хүртэл халдвар, хамгааллын дэглэм баримтлан 22 цаг хүртэл ажиллахыг зөвшөөрсүгэй.

2.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн А/403 дугаар захирамжийн 2 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Дээрх байгууллагуудын үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр), Цагдаагийн газар (хурандаа Б.Мөнх-Эрдэнэ), аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), сумын Засаг дарга нарт даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101074